РЕМИКОН ХК

# 2018 оны жилийн эцсийн тайлан

2019.03.19

# Үйл ажиллагааны тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

- 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 44 ажилтантайгаар М0-М500 хүртэлх маркын бетон зуурмаг мөн тусгай зориулалтын ус нэвтэрдэггүй бетон зуурмаг үйлдвэрлэж, зах зээлд 59,904 м.куб бетон зуурмаг борлуулж, 9,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, тайлант хугацаанд 428 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Энэ нь өмнөх жилүүдтэй харьцуулахад алдагдал 76%-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Алдагдал буурсан нь бетон зуурмагийн борлуулалт 9.2%-аар попмны борлуулалт 50%аар нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Нийт борлуулалтын хэмжээ*
(м.куб)




*Нийт борлуулалтын орлого*
(сая.төг)




*Цэвэр ашиг/алдагдал*
(сая төгрөг)




*Нийт ажилчдын тоо*
(хүн)



# Үйл ажиллагааны тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

### Орон тоо

Нийт ажилчдын тоог 5 жилээр харьцуулж үзвэл Үйлдвэр технологи болон оффисын ажилчид харьцангуй тогмтол харин авто тээвэр түгээлтийн ажилчид ихээр өөрчлөлттэй байна. Энэ нь жолооч нар бөгөөд 2014 онд 35 жолоочтой байсан бол одоогоор 18 жолоочтой ажиллаж байна.

- 2014 онд 77 ажилчидтай
- 2015 онд 53 ажилчидтай
- 2016 онд 43 ажилчидтай
- 2017 онд 43 ажилчидтай
- 2018 онд 44 ажилчидтай тус тус ажиллаж байна.

**Нийт ажилчдын тоо /2014-2018 он/**



# Үйл ажиллагааны тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

**Олон улсын бетон судлалын бага хурал**

**2018.06.15**





# Үйл ажиллагааны тайлан

Зуун зуунд
Нугаршгүй чанар

**ACI-н бетоны техникчийн сургалт**
**2018.07.03**



# Үйл ажиллагааны тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

**Бетон замын технологийн өдөрлөг**

**2018.04.19**





# Үйл ажиллагааны тайлан



- Логогоо өөрчилсөн.

Өмнөх лого

Шинэчилсэн лого

- ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

# Борлуулалтын тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*




Борлуулалтын хэмжээг сүүлийн 2 жилээр сар сараар харвал 2018 онд өмнөх оноос 9%-аар илүү борлуулалттай байсан ба кубээр харвал 5,064 м.куб зуурмаг илүү борлуулсан байна. Мөн 2018 онд 3-р сарын сүүлээр борлуулалт гарч байсан бол 2017 онд 4-р сараас эхэлж байсан байна. Сар сарын борлуулалтын задаргааг харахад 2018 онд 4, 5, 10, 11 саруудад илүү борлуулалт хийсэн. Харин 6, 7, 8, 9 саруудад бага борлуулалт хийсэн байна.

# Борлуулалтын тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*



# Борлуулалтын тайлан

Зуун зуунд
Нугаршгүй чанар




Борлуулалтын хэмжээг харилцагчийн тоотой сар сараар харьцуулж харвал зун, намрын оргил саруудад харилцагчийн тоо тогтмол өсөлттэй ба ажлын улирал дуусах үед харилцагчийн тоо эрс багасч байна. Ажлын саруудад давхардсан тоогоор 220 харилцагчидтай хамтарч ажилласан бөгөөд хамгийн их кубын ажил гарсан сард хамгийн их харилцагчтай байсан байна.

# Санхүүгийн тайлан

Зуун зуунд
Нугаршгүй чанар

**ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

- Орлого үр дүнгийн тайлангаас харвал борлуулалтын орлого өмнөх жилээс 17%-аар өссөн бол үүнийг дагаад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 17%-аар өсч нийт ашиг мөн 18%-аар өссөн байна. Харин үйл ажиллагааны зардал 5%-аар буурсан байна. Мөн зээлийн хүүгийн зардал 6%-аар буурсан ба энэ нь богино хугацаат банкны зээл буурсантай холбоотой байн. Тайлант хугацааны цэвэр алдагдал 67% буюу 3 дахин буурсан байна.
- Тайлангийн шинжилгээнээс харахад нийт ашгийн маржин өмнөх оноос 0,3%-аар, үйл ажиллагааны ашгийн маржин 5%-аар, Цэвэр ашгийн маржин 11%-аар өссөн үзүүлэлт гарсан байна.

**Орлого үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/**

| Он | 2016 | 2017 | 2018 | ӨОМҮ |
|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 8,601 | 7,823 | 9,188 | 117% |
| ББӨ | 5,844 | 5,372 | 6,304 | 117% |
| **Нийт ашиг** | **2,757** | **2,451** | **2,884** | **118%** |
| Үйл ажиллагааны зардал | 1,253 | 1,706 | 1,617 | 95% |
| **Үйл ажиллагааны ашиг** | **1,504** | **745** | **1,267** | **170%** |
| Элэгдлийн зардал | 635 | 774 | 527 | 68% |
| Зээлийн хүүгийн зардал | 1,717 | 1,368 | 1,287 | 94% |
| **Татварын өмнөх ашиг** | **-848** | **-1,397** | **-547** | **39%** |
| Ү/а-ны бус орлого | -18 | 122 | 119 | 98% |
| Орлогын татвар | 3 | 4 | 0.2 | 6% |
| **Цэвэр ашиг/алдагдал** | **-869** | **-1,279** | **-428** | **33%** |
| Нийт ашгийн маржин | 32% | 31% | 31% | 0.06% |
| Үйл ажиллагааны ашгийн маржин | 17% | 10% | 14% | 4% |
| Цэвэр ашгийн маржин | -10% | -16% | -5% | 12% |
| EBITDA маржин | -10% | -18% | -6% | 12% |

# Санхүүгийн тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ЗАДАРГАА

Орлого үр дүнгийн тайлангаас борлуулалтын орлогын задаргааг харвал бетон зуурмагийн борлуулалт 14% буюу 1,0 тэрбум төгрөг, помпны борлуулалт 11% буюу 25 сая төгрөг, түрээсийн орлого 276% буюу 105 сая төгрөг түлш борлуулалтын орлого 141% буюу 210 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

**Орлого үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/**

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2018/2017 |
|---|---|---|---|---|
| Бетон зуурмаг борлуулалтын орлого | 8,173,237 | 7,395,034 | 8,418,063 | 114% |
| Помпны орлого | 132,742 | 236,477 | 261,982 | 111% |
| Түрээсийн орлого | 154,981 | 37,884 | 142,703 | 377% |
| Түлш борлуулалтын орлого | 99,048 | 149,279 | 359,694 | 241% |
| Бусад орлого | 41,102 | 4,585 | 5,566 | 121% |
| **Нийт борлуулалтын орлого** | **8,601,110** | **7,823,259** | **9,188,009** | **117%** |

# Санхүүгийн тайлан

Зуун зуунд
Нугаршгүй чанар

## Үйл ажиллагааны зардлын задаргаа

Үйл ажиллагааны зардлыг өмнөх онтой харьцуулж харвал 11%-аар буурсан байна. Задаргааг харвал цалингийн зардал 13%-аар, НДШ 41%-аар, түлшний зардал 65%-аар түрээсийн зардал 98%-аар, оношлогоо татварын зардал 354%аар тус тус өссөн байна.

Харин шуудан холбоо, хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, даатгал, гэрээт ажил борлуулалтын зардал гэх мэт зардлууд буурсан байна.

**Үйл ажиллагааны зардал /мян төгрөгөөр/**

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2017/2018 |
|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны зардал** | **3,604,571** | **3,847,909** | **3,431,271** | **89%** |
| Цалин, нэмэгдэл, урамшуулал | 500,660 | 486,185 | 549,040 | 113% |
| НДШ | 57,223 | 57,254 | 80,492 | 141% |
| Түлш, унаа | 293,101 | 322,520 | 532,720 | 165% |
| Гар утас, шуудан холбоо | 19,828 | 19,076 | 18,242 | 96% |
| Томилолтын зардал | 6,219 | 13,400 | 15,743 | 117% |
| Борлуулалтын зардал | 130,177 | 423,324 | 125,363 | 30% |
| Хөдөлмөр хамгаалал | 324 | 3,849 | 1,638 | 43% |
| Хангамжийн материалын зардал | 6,551 | 5,303 | 4,442 | 84% |
| Түрээсийн зардал | 11,433 | 9,190 | 18,162 | 198% |
| Сэлбэг, хэрэгслийн зардал | 88,844 | 161,015 | 128,119 | 80% |
| ТХ-ийн даатгалын зардал | 8,833 | 12,434 | 6,469 | 52% |
| ТХ-ийн оношлогоо, түрээс г.м зардал | 25,176 | 1,704 | 25,343 | 1487% |
| Элэгдлийн зардал | 634,791 | 773,941 | 526,879 | 68% |
| Гэрээт ажил | 34,793 | 110,081 | 54,769 | 50% |
| Хүнсний зардал | 3,944 | 1,544 | 1,628 | 105% |
| ҮХХ, АТӨЯХ-н татвар | 45,219 | 58,258 | 31,280 | 54% |
| Зээлийн хүү, санхүүжилтын зардал | 1,716,658 | 1,367,695 | 1,288,811 | 94% |
| Байгаль орчин, үнэлгээний зардал | 5,000 | - | 0 | 0% |
| Зар сурталчилгааны зардал | 9,441 | 10,040 | 9,914 | 99% |
| Үйл ажиллагааны бусад зардал | 6,356 | 11,096 | 12,218 | 110% |

# Санхүүгийн тайлан

*Зуун зуунд*
*Нугаршгүй чанар*

## Баланс

Санхүү байдлын тайлангаас харахад 2018 онд эргэлтийн хөрөнгө 2%-аар өссөн ба эргэлтийн бус хөрөнгө 11%-аар буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнтэй холбоотой ба зарим хөрөнгө элэгдлээрээ дууссан байна.

Өр төлбөрийн дүн 1%-аар буурсан нь ХХБ-ны зээлтэй хоблоотой бууралт ба эзний өмч 7%-аар буурсан нь тайлант үеийн хуримтлагдсан алдагдал өссөнтэй холбоотой байна.

**Санхүүгийн байдал /сая төгрөгөөр/**

| | 2016 | 2017 | 2018 | 2018/2017 |
|---|---|---|---|---|
| Эргэлтйн хөрөнгө | 11,944 | 12,286 | 12,532 | 102% |
| Эргэлтийн бус хөрөнгө | 9,324 | 7,528 | 6,726 | 89% |
| **Нийт актив** | **21,268** | **19,814** | **19,259** | **97%** |
| Өр төлбөр | 13,887 | 13,712 | 13,584 | 99% |
| Эздийн өмч | 7,382 | 6,102 | 5,674 | 93% |
| **Нийт пассив** | **21,268** | **19,814** | **19,259** | **97%** |



# Санхүүгийн тайлан

Зуун зуунд
Нугаршгүй чанар

## Мөнгөн урсгал

Мөнгөн урсгалын тайлангаас харвал 2018 онд мөнгөн орлого 15%-аар буурсан ба үүнийг дагаад мөнгөн зарлага 18%-аар буурсан байна.

Мөн бид 2018 оны эхэнд мөнгөний үлдэгдэл 1,3 тэрбум төгрөг байсан ба 2018 онд зээлийн төлбөрт 2,8 тэрбум төгрөг төлж оны эцсээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10 сая болж буурсан байна.

**Үйл ажиллагааны зардал /мян төгрөгөөр/**

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2018/2017 |
|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | |
| ***Мөнгөн орлого*** | **4,674,097** | **7,070,628** | **5,986,313** | **85%** |
| Бараа борлуулсны орлого | 4,539,184 | 6,494,255 | 5,713,111 | 88% |
| Бусад мөнгөн орлого | 134,914 | 576,373 | 273,203 | 47% |
| ***Мөнгөн зарлага*** | **4,106,820** | **5,519,476** | **4,505,703** | **82%** |
| Ажилчдад төлсөн | 468,218 | 448,495 | 515,937 | 115% |
| НД-ын байгууллагад төлсөн | 108,650 | 210,700 | 191,070 | 91% |
| ТЭМ худалан авахад төлсөн | 2,513,268 | 3,057,726 | 2,650,975 | 87% |
| Ашиглалтын зардалд | 2,070 | 176 | - | 0% |
| Түлш болон сэлбэг хэрэгсэлд төлсөн | 219 | 835 | 140 | 17% |
| Хүүний төлбөрт төлсөн | 199,336 | 156,374 | 66,827 | 43% |
| Татварын байгууллагад төлсөн | 379,971 | 343,329 | 326,258 | 95% |
| Даатгалд төлсөн | - | - | 6,469 | 100% |
| Бусад мөнгөн зарлага | 435,088 | 1,301,839 | 748,027 | 57% |
| **Ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **567,278** | **1,551,153** | **1,480,611** | **95%** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | | |
| Хүлээн авсан хүүгийн орлого | 786 | 523.89 | 425.98 | 81% |
| **ХО-ын ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **786** | **524** | **426** | 81% |
| **Санхүүгийн ү/а-ны мөнгөн гүйлгээ** | | | | |
| Банкны зээл | 600,000 | - 212,800.00 | - | 0% |
| Зээлд төлсөн | (1,302,100) | - | (2,820,427) | |
| Ханшийн тэгшитгэл | 34,084 | -5,226.24 | -10,750.40 | 206% |
| **Санхүүгийн ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(668,016)** | **(218,026)** | **(2,831,177)** | **1299%** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | (99,952) | 1,333,650 | (1,350,140) | -101% |
| **Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл** | 126,523 | 26,566 | 1,360,217 | 5120% |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **26,571** | **1,360,217** | **10,076** | **1%** |

# Зээлийн мэдээлэл

Зуун зуунд
Нугаршгүй чанар

## ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

- 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 13.06 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд бид ХХБ-ны зээлээс 437 сая төгрөг барагдуулсан бөгөөд тус зээлийг ХХБ-ны 8%-ийг ашиглан орон сууц борлуулж барагдуулсан.
- Харин МСМ-ийн зээлийг 2018 онд зээлийн хүүг 8% болгож үндсэн зээлийг 3 жилийн хугацаанд бэлэн мөнгөөр төлөхөөр тохиролцоонд хүрсэн боловч санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж хуримтлагдсан хүү болох 2,5 тэрбум төгрөгийг төлсөн ба тухайн жилийн хүүг төлж чадаагүй байна.

**Зээлийн мэдээлэл /сая.төгрөг/**

| | Валют | Эхний үлдэгдэл | Төлөлт | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| MCM PTE Ltd | Төгрөг | 7 497.4 | - | 7 497.4 |
| Хуримтлагдсан хүү | Төгрөг | 3 099.8 | 2 500 | 599.8 |
| Худалдаа хөгжлийн банк | Төгрөг | 567.3 | 437.3 | 130 |
| Нийт зээлийн дүн | | 10 564.7 | 2 937.3 | 8 227.2 |

# Хувьцааны мэдээлэл



### Хувьцааны арилжаа

2018 оны жилийн эцсийн байдлаар Ремикон ХК-ийн хувьцаа нийт 5,011,724 ширхэг буюу 174.1 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад /15,118,990/ 3 дахин буурсан байна. Хувьцааны дундаж үнэ 36.54 төгрөг болж дундаж ханш өмнөх оноос /43.86/ 7,3 төгрөгөөр буурсан байна.



# Хувьцааны мэдээлэл

Зуун зуунд
Нугаршгүй чанар

### Хувьцааны арилжаа

2018 оны жилийн эцсийн байдлаар Ремикон ХК-ийн хувьцаа нийт 5,011,724 ширхэг буюу 174.1 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 67% буурсан байна. Хувьцааны дундаж үнэ 36.54 төгрөг болж өмнөх оноос 17%-аар, хувьцааны арилжааны үнийн дүн 74%-аар тус тус буурсан байна.

**Хувьцааны арилжаа**

| он | 2016 | 2017 | 2018 | ӨОМҮ |
|---|---|---|---|---|
| Арилжаалагдсан хувьцааны тоо | 4 110 770 | 15 118 990 | 5 011 724 | 33% |
| Дундаж хаалтын ханш | 55.51 | 43.86 | 36.54 | 83% |
| **Нийт үнийн дүн /сая төгрөг/** | **228,19** | **663,12** | **174,1** | **26%** |

РЕМИКОН ХК

# Баярлалаа

*Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон-181, РЕМИКОН ХК-ний үйлдвэрийн байр*

*Борлуулалт Маркетингийн алба: Утас: 777-7704, 88881247, 88109680*